



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/165

Номгон

Дулааны станц барих ажлын явцад
хяналт тавьж ажиллах ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймагт баригдаж байгаа 35мВт хүчин чадалтай дулааны станц барих ажлын явцад ажил эхлэхээс дуусах хүртэл хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга Т.Отгонбаатар – Баянхонгор тохижилт үйлчилгээ Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал

Д.Ихбаяр – Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

С.Хүрэлхуяг – Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Г.Энхбаяр – Баянхонгор сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч

С.Цэдэнсодном - “Чандмань-Баянхонгор” ХК-ийн ерөнхий инженер

Т.Норовринчин – Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Дэд бүтэц, барилга, орон сууцны бодлого хариуцсан мэргэжилтэн

Б.Базарсад – Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Зам, тээврийн асуудал хариуцсан мэргэжилтэн

М.Мөнхбат – Хууль, эрх зүйн хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

Д.Магван - Хууль, эрх зүйн хэлтсийн Авто зам, тээврийн хяналтын улсын ахлах байцаагч

Ж.Уламбаяр – “Баянхонгор эрчим хүч” Цахилгаан түгээх ХХК-ийн гүйцэтгэх захирал

Б.Баярсайхан – Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Баянхонгор аймгийн газрын дарга

642310489


2.

Дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн захирлууд

Нарийн бичгийн дарга Т.Хишигбаатар - Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

2.Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Т.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН